



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/138

Номгон

Г Гэр бүлийн өдөртэй болох тухай Г


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутагт 2024 оныг "Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган сар бүрийн эхний 7 хоногийн Баасан гарагийг "Гэр бүл"-ийн өдөр болгон хэвшүүлж тухайн өдөр албан байгууллага, аж ахуйн нэгжүүд ажлын цагаа 10:00-13:00, 14:00-17:00 цаг болгон /ажлын цагаа уян хатан байлгах/ эцэг эх, асран хамгаалагчид нь хүүхдүүдийнхээ сурлага, хөгжил, төлөвшилд зарцуулах цаг гаргах зорилгоор ажилтан, албан хаагчиддаа цагийн цалинтай чөлөө олгож байхаар тогтоосугай.

2. Тогтоосон гэр бүлийн өдрөөр гэр бүлээрээ хамтдаа цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцах, сурлага, хөгжил, төлөвшлийн талаар анги удирдсан багштай ярилцах, санал солилцох, хүүхэддээ цаг гаргах, албан байгууллага, аж ахуйн нэгжүүд гэр бүлд ээлтэй орчинг бүрдүүлэх, үйлчилгээний байгууллагууд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөнгөлөлт урамшууллыг бий болгох зэрэг шинэлэг санал санаачилга гарган ажиллахыг эцэг эх, асран хамгаалагчид, хүүхдийн төлөө үүрэг хүлээгч байгууллагуудад үүрэг болгосугай.

3. Олон Улсын гэр бүлийн өдөр буюу жил бүрийн 05 дугаар сарын 15-ны өдрийг бүх нийтээрээ тэмдэглэн өнгөрүүлж, нийт ажилтнуудын гэр бүлд чиглэсэн ажил арга хэмжээг зохион байгуулахыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын дарга, эрхлэгч, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг)-т, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН

024010253